Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ISO45001:2018 ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг “Ололт-Амжилт” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээ авсан ба захирлын тушаалаар 2 ажлын хэсэг томилогдон нийт 10 сарын хугацаанд хийж гүйцэтгэн баталгаажуулалтын аудитад шалгуулан, амжилттай хамгаалж ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажиллаж буйгаа баталгаажуулсан гэрчилгээг /3 жилийн хугацаатай/ гардан авсан.

ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт 8-н журам, 25-н процессын зураг боловсруулсан байна. Үүнд:

Дөрөвдүгээр бүлэг:

- 4.1 Байгууллагын төлөв байдлын судлагаа, шинжилгээ хийсэн.
- 4.2 Сонирхогч талуудын судлагаа, шинжилгээ хийсэн.
- 4.3 ХАБЭА-н МТ-ны хамрах хүрээ, бодлого тодорхойлсон.

Тавдугаар бүлэг:

- 5.1 Удирдлагын амлалт буюу Гүйцэтгэх захирал 10-н амлалт өгсөн.
- 5.2 ХЭМАБ-н бодлогоо тодорхойлж нийт ажилтнуудад танилцуулсан.
- 5.3 Ажлын байрны тодорхойлолтуудад ХАБЭА-н талаар нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 5.4 ХАБЭА-н зөвлөлийн журамыг шинэчилэн болосруулсан.

Зургаадугаар бүлэг:

- 6.1 Хуулийн нийцэл хийж, өндөр эрсдэлтэй ажлын байрнуудад эрсдлийн үнэлгээ дахин шинэчилж хийсэн.
- 6.1 Эрсдэл хяналтын журам боловсруулсан.
- 6.2 ХАБЭА-н 2024 оны зорилт, төлөвлөгөөг боловсруулсан.

Долдугаар бүлэг:

- 7.2 Чадамжийн үнэлгээ ИТА нараас авч чадамжийг үнэлсэн.
- 7.3 ХАБЭА-н сургалт зааварчилгааны журам боловсруулсан.
- 7.4 Мэдээлэл харилцааны матриц боловсруулсан.
- 7.5 Бичиг баримт боловсруулалт, хяналт бүртгэлийн журам

Наймдугаар бүлэг:

- 8.1 ХАБЭА-н хяналтын журам боловсруулсан.

8.2 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилэгдсэн журмын дагуу шинэчилж батлуулсан.

Есдүгээр бүлэг:

9.1 Дотоод аудит хийх журам боловсруулсан.

9.2 Дотоод аудит хийсэн.

9.3 Удирдлагын дүн шинжилгээний хурал хийсэн.

Аравдугаар бүлэг:

Аюултай тохиолдолыг судлан бүртгэх журам боловсруулсан.

Зураг№ 64



Зураг№ 65



ХАБЭА-н МТ-ны бичиг баримт боловсруулах ажил хийгдэж байгаа үйл явц

Зураг№ 66



Зураг№ 67



ХАБЭА-н МТ-ны сургалтанд сууж байгаа үйл явц

Зураг№ 68

Зураг№ 69



Дотоод аудиторын сургалтанд хамрагдаж буй үйл явц

ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо хэрэгжүүлсний гэрчилгээгээ гардан авч байгаа нь

Зураг№ 70



ХАБЭА-н +3м тэмцээн

Дэлхийн ХАБЭА-н өдрийг угтан “ХАБЭА-н +3М” тэмцээнийг “Амгалан дулааны станц ТӨХК”-ийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу 04-р сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд баг тус бүр 6-н хүний бүрэлдэхүүнтэй, 5 баг оролцож хурд, хүч, авхаалж самбаагаа сорьж өрсөлдсөнөөс

1-р байранд – ЗУХ-СЭЗХ-ИХ

2-р байранд – Зуухан цех

3-р байранд – ТДЦех тус тус эзлэж мөнгөн шагналаар шагнуулсан.

Хөгжөөн дэмжигчдын дундах тэмцээнд ЗУХ-СЭЗХ-ИХ 1-р байр, Нэгдсэн цехийн хөгжөөн дэмжигчид 2-р байрыг тус тус эзэлсэн.

Зураг№ 71

Зураг№ 72



ХАБЭА +3 тэмцээний үйл явц

Зураг№ 73

Зураг№ 74



ХАБЭА +3 тэмцээний үйл явц

Зураг № 75



Зураг № 76



ХАБЭА +3 тэмцээний үйл явц

Зааварчилгааны талаар


ХАБЭА-н тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8 дахь заалт болон Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн 12 дугаар бүлгийн дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүрт өгч, хяналт тавьж ажилласан. Мөн 3 минут 32 секунд үргэлжилжх зочдын зааварчилгаа, 16 минут 41 секунд үргэлжилэх урьдчилсан зааварчилгааг видео хэлбэрт оруулж хийлгэсэн.

Зочдын зааварчилгаа:

Зураг № 77

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН **АЛТАН** ДҮРЭМ

- 1 Та өөрийнхөө болон бусдын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
- 2 Бүх ослоос урьдчилан сэргийлэх боломжтой.
- 3 Ажлыг хялбарчлахгүйгээр аюулгүйн дүрмийн дагуу гүйцэтгэнэ.
- 4 Хэрэв та сургалтад хамрагдаагүй бол тухайн ажлыг бүү хий.
- 5 Аюулгүйн ажиллагааны шаардлага хангасан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах.
- 6 Ажлаа эхлэхийн өмнө эрсдэлээ үнэлэх.
- 7 Биед тохиромжгүй ажлын хувцас хэрэглэхгүй байх.
- 8 Ажлаа гүйцэтгэж байхдаа анхаарлаа сарниулж болохгүй.
- 9 Ажлын байрыг эмх цэгцтэй цэвэр байлгах.
- 10 Хувийн хамгаалах хэрэгслийг байнга хэрэглэж хэвших.



Урьдчилсан зааварчилгаа:

Зураг № 78




Нийт ажилтаны зааварчилгаанд хамрагдсан байдал

Хүснэгт № 81

№	Агуулга	Зааварчилгаа авсан ажилтан (Давхардсан тоогоор)
1	Урьдчилсан зааварчилгаа	124
2	Анхан шатны зааварчилгаа	72
3	Зочидын зааварчилгаа	286
4	Өдөр тутмын зааварчилгаа	19127
5	Сарын давтан зааварчилгаа	1527
6	Ээлжит бус зааварчилгаа	331
7	Тухайлсан зааварчилгаа	320
Нийт		21787

График № 28

НИЙТ ЗААВАРЧИЛГАА



Мэдлэгийн шалгалт

Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 15-р бүлэгт заасны дагуу 2024 оны мэдлэгийн шалгалтыг III/25-V/09-ны хооронд нийт 3 удаа зохион байгуулсан. Мэдлэгийн шалгалтын нийт 220 тест боловруулсан.

Үүнд:

1. ААД-ийн 3-р бүлгээс нийт 50 тест
2. ТАД-ийн 1.4-1.5, 3,4,5,6, -р бүлгээс нийт 105 тест
3. Зуухны ашиглалтын заавраас 20 тест
4. ЭХҮААНБДМГАБ-ын дүрмээс 20 тест
5. ТДЦех, Зуухан цех, Хими хэсгийн ашиглалтын заавруудаас тус бүр 15 тест
6. Анхны тусламжын 10 тест


Жинхлэх болон зэрэг нэмэх шалгалтыг Сургалт, судлагааны мэргэжилтэнтэй хамтран тухай бүрт нь зохион байгуулж ажилласан.

Мэдлэгийн шалгалтанд хамрагдсан байдал


Хүснэгт № 82

№	Шалгалтын төрөл	Шалгалтанд хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/
1	Ээлжит	132
2	Ээлжит бус /гэнэтийн/	7
3	Жинхлэх	55
4	Зэрэг нэмэх	28
Нийт		165

График № 29





ЗЭРЭГ НЭМЭХ ШАЛГАЛТ



Зураг № 79

Зураг № 80



Мэдлэгийн шалгалтын үйл явц

Зураг № 81



Зураг № 82



Мэдлэгийн шалгалтын үйл явц

Ажлын хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгсэл

Нийт ажилтнуудад ажлын хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгсэл олголтонд батлагдсан нормын дагуу олголт болон хэрэглээнд тогтмол хяналт тавьж, бүртгэл хөтлөж ажилласан. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлийн нормыг жил бүр шинэчилэн батлуулан ажиллаж байна.

Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл олгосон байдал

Хүснэгт № 83

№	Цех, нэгжийн нэр	Өвөл		Зун		С/цамц	Бомбор	Каск	Эрүүвч
		Хувцас	Гутал	Хувцас	Гутал				
1	Хяналтын хэлтэс	4	3	4	5	6	5	1	
2	ЗУХЭлтэс	6	6	4	2	6	3	3	
3	СЭЗХэлтэс	1	1	0	0	0	2	1	
4	ҮБШАХэлтэс	3	3	7	5	5	7	2	
5	Хангамжийн хэлтэс	6	7	3	3	2	5	6	
6	Зуухан цех	25	24	38	32	20	31	23	
7	ТДЦех	40	43	44	43	8	40	17	2
8	Нэгдсэн цех	26	29	36	27	13	29	15	
9	Засварын цех	17	18	18	12	17	17	5	
10	АХММХэсэг	19	19	10	2	0	11	8	
Нийт		147	153	164	131	77	150	81	2


Ажлын хувцас, гутал болон хувийн хамгаалах хэрэгсэлийн зөрчил

Хүснэгт № 84

№	Цех, нэгж	Каск өмсөөгүй, бүчлээгүй	Ажлын хувцас өмсөөгүй	Ажлын гутал өмсөөгүй	Хамгаалах бүс хэрэглээгүй	Нийт
1	Зуухан цех	19	-	1	-	20
2	ТДЦех	2	-	-	-	2
3	Нэгдсэн цех	6	4	1	1	12
4	Засварын цех	10	4	-	-	14
5	АХММХэсэг	7	-	-	-	7
6	Хангамжийн хэлтэс	1	-	-	-	1
7	ҮБШАХэлтэс	2	1	1	-	4
8	СЭЗХэлтэс	4	1	-	-	5
Нийт		51	10	3	1	65

Илэрсэн зөрчлийг хувиар харуулвал

График№31



Эрүүл мэндийн ээлжит үзлэг

“ХАБЭА-н тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 болон Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10-р сарын 20-ний өдөр батлагдсан А/340 тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ийн дагуу нийт ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах ажлыг “Бриллиант” эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 2024 оны 08-р сараас 09-р сарын хооронд зохион байгуулсан. Эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2 багц үзлэгийн хүрээнд нийт 171 ажилтан хамрагдсан.

Үзлэгт хамрагдсан байдал

Хүснэгт № 85

Эрүүл		Эмгэг		Нийт
31	18,3%	138	81,6%	171
Эрэгтэй		Эмэгтэй		Нийт
126	74,5%	43	25,4%	171

	Багц 1	Багц 2
Эрэгтэй	98	28
Эмэгтэй	25	20


Өвчлөлийн байдал

Хүснэгт № 86

№	Өвчний нэр /эрхтэн системээр/	Өвчтэй ажилтан	Хувь
1	Хоол боловсруулах замын эрхтэн системийн өвчлөл	86	50.8%
2	Зүрх судасны эрхтэн системийн өвчлөл	13	7.6%
3	Бөөр шээсний замын өвчлөл	26	19.8%
4	Бодисын солилцооны хам шинж	71	42.0%
5	Дотоод шүүрлийн эмгэг	10	5.9%
6	Цус багадалт	2	1.1%
7	Витамин Д дутагдал	26	15.3%
8	Эрүүл	31	18.3%

График №32

АЖИЛЧДЫН ӨВЧЛӨЛ /ХУВИАР/



Дээрх дүнгээс харахад нийт ажилчдын дунд хоол боловсруулах замын эрхтэн системийн өвчлөлүүд болон бодисын солилцооны хам шинж хамгийн түгээмэл тархсан байгаа нь харагдаж байна.

Албан шаардлага, мэдэгдэх хуудас

Ажлын байрны эргэлт, шалгалтыг өдөр тутам тогтмол хийж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдалуудыг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Албан шаардлага

Хүснэгт № 87

№	Цех, нэгж	Дугаар	Албан даалгавар	Биелэлт
1	Хангамжийн хэлтэс	01	Гражын цэвэрлэгээ, золбин нохой зайлуулах, аюулгүй байдал хангуулах	100%
2	Хунан ххк	02	Гражын цэвэрлэгээ, ажилтнуудын аюулгүй байдал хангах	100%
3	Хунан ххк	03	Зуух №4-т үүссэн гэмтэл арилгуулах	100%
4	Зуухан цех	04	Ажлын байрны эргэлт шалгалтаар илэрсэн зөрчил арилгуулах тухай	100%
5	ТДЦех	05	Галын аюулгүй байдал хангах	0%
6	ҮБШАХэлтэс	06	Галын аюулгүй байдал хангах	0%
7	Нэгдсэн цех	07	Компрессор №4-ийн цахилгаан хөдөлгүүрийн холхивчны доргионы гэмтэл арилгах	100%
8	Зуухан цех	08	Компрессор №4-ийн цахилгаан хөдөлгүүрийн холхивчны доргионы гэмтэл арилгах	100%
9	Зуухан цех	09	Ажлын байрны тоосжилт бууруулах арга хэмжээ авах	100%
Нийт				77.7%

Мэдэгдэх хуудас

Хүснэгт № 88

№	Цех, нэгж	Дугаар	Албан даалгавар	Биелэлт
1	Зуухан цех	01	ГАБ-ын тухайлсан зааварчилгаа өгөх	100%
2	ТДЦех	02	ГАБ-ын тухайлсан зааварчилгаа өгөх	100%
3	Нэгдсэн цех	03	ГАБ-ын тухайлсан зааварчилгаа өгөх	100%
4	АХММХэсэг	04	ГАБ-ын тухайлсан зааварчилгаа өгөх	100%
5	Хунан ХХК	05	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
6	Зуухан цех	06	Гүйцэтгэлийн тайлан гаргаж өгөх	100%
7	ТДЦех	07	Гүйцэтгэлийн тайлан гаргаж өгөх	100%
8	ҮБШАХ	08	Гүйцэтгэлийн тайлан гаргаж өгөх	100%
9	Хунан ХХК	09	ГАБ-ийн дүрэм мөрдөж ажиллах	100%

10	Зуухан цех	10	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
11	Зуухан цех	11	Нарядын систем мөрдөж ажиллах	100%
12	Хангамжийн хэлтэс	12	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
13	Зуухан цех	13	ГАБ-ийн дүрэм мөрдөж ажиллах	100%
14	ТДЦех	14	ГАБ-ийн дүрэм мөрдөж ажиллах	100%
15	Зуухан цех	15	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
16	Нэгдсэн цех	16	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
17	ҮБШАХ	17	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
18	Хангамжийн хэлтэс	18	Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	100%
19	Хангамжийн хэлтэс	19	Ажлын хувцас хугацаанд нь олгох	100%
20	СЭЗХэлтэс	20	Химийн бодисын агуулахын шаардлага хангуулах	100%
21	Нэгдсэн цех	21	ТАД-ын дүрэм мөрдөж, засварын чанарыг сайжруулах	100%
22	Хангамжийн хэлтэс	22	ГАБ-ыг хангуулах тухай	50%
23	АХММХэсэг	23	Ажлын байрны эргэлт шалгалтаар илэрсэн зөрчил арилгуулах	100%
24	Зуухан цех	24	ТАД мөрдөх, тоноглолын засвар үйлчилгээг сайжруулах	100%
25	ТДЦех	25	ТАД мөрдөх, тоноглолын найдвартай ажиллагааг хангах	100%
26	Хангамжийн хэлтэс	26	Ажилтнуудын аюулгүй байдал хагуулах, золбин нохой устгуулах	100%
Нийт				98%

Аюулгүй ажиллагааны сургалт

“Амгалан дулааны станц” ТӨХК нь хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх үүднээс ХАБЭА-н сургалт явуулах АДС/20240201046 тоот дугаартай тендер зарлаж “МОНГОЛЫН ЦАХИМ ИНСТИТУТ” ТББайгууллага шалгаран ХАБЭА-н нийт ажилтны сургалт болон ажил олгогч, удирдах ажилтны ХАБЭА-н сургалтуудыг амжилттай зохион байгуулсан.

Нийт ажилтны сургалтыг ажлын онцлогоос улбаалан хавар болон намар 2 хувааж зохион байгуулсан бөгөөд эхний сургалтыг 2024 оны 05-р сарын 15-ны өдөр зохион байгуулж нийт 57 ажилтан хамрагдсан бол 2024 оны 08-р сарын 13-ны өдөр 29 ажилтан, 2024 оны 09-р сарын 25-ны өдөр 40 ажилтан, 2024 оны 09-р сарын 27-ны өдөр 32 ажилтан тус тус сургалтад хамрагдаж нийт 158 ажилтан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны хамрагдвал зохих сургалтад идэвхтэй оролцсон байна. Сургалтыг Монгол Улсын зөвлөх инженер Б.Шинэбаяр, ХАБЭА-н сургагч багш Б.Баатар, Эрүүл ахуйч эмч Ц.Сансарцэцэг нар тус тус удирдан явуулсан.

Ажил олгогч, удирдах ажилтны хамрагдвал зохих хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2024 оны 08-р сарын 10-ны өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 14

ажилтан сургалтад хамрагдаж, хүн тус бүрт сертификат олгов. Тус сургалтыг ХАБЭА-н сургагч багш Б.Баатар, Эрүүл ахуйч эмч Ц.Сансарцэцэг нар удирдан явуулсан.

Мөн Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтгэстэй хамтран “Гал унтраах тактикийн сургалт”-ыг 2024 оны 10-р сарын 14-ний өдөр Амгалан дулааны станцын ажлын байран дээр амжилттай зохион байгуулсан. ГТУА 063-р ангиас гал унтраах тусгай зориулалтын 4 авто машин, 35-р ангиас гал унтраах тусгай зориулалтын 2 автомашин, нийт гал унтраах тусгай зориулалтын 6 автомашинтайгаар, 36 хүний бие бүрэлдэхүүн сургалтыг зохион байгуулсан.

Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх практик сургалтыг 2024 оны 10-р сарын 21-24-ний өдрүүдэд явуулсан бөгөөд нийт 4 ээлжийн 111 ажилтан хамрагдсан болно. Тус сургалтыг Монголын улаанзагалмайн нийгэмлэгийн сургагч багш Н.Гэрэлмаа, А.Дөлгөөн нар удирдан явуулсан бөгөөд тус сургалтын үеэр БЗД-ийн Улаанзагалмайн нийгэмлэгээс хиймэл амьсгал хийх маникеныг гардуулан өгсөн.

Сургалтанд хамрагдсан байдал

Хүснэгт № 89

№	Сургалтын нэр	Сургалтанд хамрагдсан ажилтан
1	Ажил олгогч, удирдах ажилтны сургалт	14
2	Нийт ажилтны сургалт	158
3	Шинэ ажилтны сургалт	8
4	Галын танхимын сургалт	57
5	Галын тактик сургуулилт	90
6	Анхны тусламжийн сургалт	111
Нийт		438

Ажилтнуудын сургалт

Зураг № 83

Зураг № 84



Зураг № 85





Зураг № 86



Галын аюулгүй байдлын танхимын сургалтын үйл явц

Зураг № 87

Зураг № 88



Галын аюулгүй байдлын танхимын сургалтын үйл явц

Зураг № 89

Зураг № 90



Аваарь, гал эсэргүүцэх дасгал

Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 14.2, 14.3 дахь заалтын дагуу Аваарь эсэргүүцэх болон гал эсэргүүцэх дасгал, Осол эсэргүүцэх дасгалыг инженерийн хэсэгтэй хамтран зохион байгуулаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Аваарь эсэргүүцэх дасгалд ашиглалтын 4-р ээлжний 18 ажилтан, ИТА- 3 нийт 21 ажилтан хамрагдсан бол осол эсэргүүцэх дасгалд Ашиглалтын 1-р ээлжийн ажилтнууд оролцсон.

Зураг № 91

Зураг № 92



Зураг № 93

Зураг № 94



Аваарь эсэргүүцэх дасгалын үйл явц

Ажлын байрны үзлэг

ХАБЭА-н 3-н шатны үзлэг

Өдөр тутмын ажлын байрны эргэлт шалгалт: ХАБЭА-н инженерүүд нь ажлын байрны эргэлт шалгалтыг өөрсдийн хариуцсан цех, нэгжид өдөр тутам хийж гүйцэтгэн ажилласан. Ажлын байрны эргэлт шалгартаар илэрсэн зөрчил дутагдалыг өдөр тутмын шуурхай зөвлөгөөнд танилцуулж, арилгах үүрэг даалгавар өгөхөөс гадна Албан шаардлага, мэдэгдэх хуудасаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Ажлын байрны эргэлт шалгалтаар илэрсэн зөрчил

Хүснэгт № 90

№	Цех, нэгж	АБЦ	ГАБ	ААД	ТАД	Нийт
1	Зуухан цех	94	34	42	11	181
2	ТДЦех	19	5	21	1	46
3	Нэгдсэн цех	24	13	20	5	62
4	Засварын цех	2	2	12	-	16
5	АХММХэсэг	6	2	8	2	18
6	Хангамжийн хэлтэс	5	6	2	-	13
7	ҮБШАХэлтэс	-	-	1	-	1
Нийт		150	62	106	19	337

Зөрчил тус бүрээр

График №33

АЖЛЫН БАЙРНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, ЭМХ ЦЭГЦ




График №34

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨРЧИЛ






График №35

ААД-ИЙН ЗӨРЧИЛ



ТАД-ИЙН ЗӨРЧИЛ



ХАБЭА-н 3-н шатны үзлэг

Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн 16 дугаар бүлгийн дагуу ХАБЭА-н 3-р шатны үзлэгийг зохион байгуулахаас гадна ХАБЭА-н 1,2-р шатны үзлэгт хяналт тавьж илэрсэн зөрчлийг аригуулах арга хэмжээ авч ажилласан.


ХАБЭА-н 3-н шатны үзлэг хийсэн тоо, илэрсэн зөрчил

Хүснэгт № 91

№	Үзлэгийн төрөл	Үзлэгийн тоо	Зөрчил		
			Илэрсэн	Арилгасан	Арилаагүй
1	I шатны үзлэг	199	67	59	8
2	II шатны үзлэг	25	21	12	9
3	III шатны үзлэг	2	46	39	7
Нийт		226	134	110	24

График №37


I ШАТНЫ ҮЗЛЭГ



■ Арилгасан ■ Арилаагүй

График №38


II ШАТНЫ ҮЗЛЭГ



■ Арилгасан ■ Арилаагүй

График №39

III ШАТНЫ ҮЗЛЭГ



Техник хяналтын чиглэлээр

Техникийн комисс

Техникийн комиссын хурлыг нийт 14 удаа зохион байгуулж нийт 30 асуудал хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Үүнд:

1. СУН №2-ын 1600кВт хүчин чадалтай давтамж хувиргуур дах 10кВ ВТ болон цахилгаан хөдөлгүүрийн кабелийг сунгаж татах.
2. Ковшийн кроп солих.
3. 2024 оны тодотголоор худалдан авах сэлбэг материал болон ажлын жагсаалт батлах
4. Зуух №1, 2, 3-ын элэгдэлтэй экран хоолойн солих тоог гаргах
5. Зуух №1,2,3-н агаар халаагчийн температурын датчик, галын хотол болон циклоны температурын датчик, даралтын датчик, зуухны шатаах камерын датчик, хаягдал утааны температурын датчикнуудыг солих шаардлагатай байгаа тул яаралтай шийдвэрлүүлэх тухай.
6. “ATLAS COPCO G250” Хийн компрессорт үйлчилгээ хийлгэх, тоноглолын найдвартай ажиллагааг хангах
7. 250кВт 2975 эрг/мин эргэлттэй цахилгаан хөдөлгүүртэй, G250 маркийн 8.5 ата даралттай, 40м3/мин агаарийн зарцуулалттай компрессор худалдан авах
8. Сүлжээний усны насос зогсох үед зуух №1, 2, 3-т уур үүсэхгүй байх нөхцлийг хангахаар технологийн хамгаалалтад өөрчлөлт оруулах
9. 439А-ийн номиналь гүйдэлтэй, 250кВт-ийн 2975 эрг/минуттай 0,4кВ-ийн цахилгаан хөдөлгүүртэй, 41.3м3/мин агаарын зарцуулалттай, 8.5 ата ажлын даралтын техникийн үзүүлэлттэй иж бүрэн компрессор шинээр суурилуулах боломжтой эсэх.

10. Сүлжээний усны насос зогсох үед зуух №1,2,3,4-т уур үүсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх зуух болон сүлжээний найдвартай ажиллагааг хангах.

Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт

Станцын хэмжээнд гарсан тоног төхөөрөмжийн гэмтлийг судлан бүртгэж тухай бүрт техникийн комиссын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлж ажилласан. Үүнд:

Хүснэгт № 92

№	Гэмтэл	Актны дугаар	Хариуцах цех хэсэг	Огноо
1	Худаг №7-ийн ганом насосны гэмтэл	№1	Зуухан цех	2024.01.11
2	Үндсэн барилга 10кВ-ийн тэжээлийн гаргалгааны кабелийн гэмтэл	№2	Нэгдсэн цех	2024.01.18
3	Зуух №3-ийн экран хоолойны гэмтэл	№3	Зуухан цех	2024.02.14
4	НО-ийн 2-р дамжлагын залуурт туузны гэмтэл	№4	ТДЦех	2024.03.11
5	Сүлжээний усны насос №3-ийн 4-р холхивчны гэмтэл	№5	Зуухан цех	2024.03.07
6	Уутат шүүлтүүр №2-ийн салхилуурын хөдөлгүүр, шугам хоолой ханзарсан гэмтэл	№6	Зуухан цех	2024.03.07
7	Худаг №7-ийн ганом насосны гэмтэл	№7	Зуухан цех	2024.04.07
8	28-74 УНӨ Нарийн үнс тээвэрлэх машины гэмтэл	№8	АХММХ	2024.04.15
9	Вагон хөмрөгийн шилжүүлэх тавцангийн хөдөлгүүрийн гэмтэл	№9	ТДЦех	2024.04.26
10	Зуух №4-ийн Б циклон	№10	Зуухан цех	2024.09.19
11	Мөнгөн тооцооны хэмжүүрийн кабелийн гэмтэл	№11	Нэгдсэн цех ДХХА хэсэг	2024.10.13
12	СУН №1 3-р холхивчийн гэмтэл	№12	Зуухан цех	2024.10.01
13	Хоёрдогч бутлуур Б гэмтэл	№13	ТДЦех	2024.10.20
14	Шаарганы бункер 2-ийн хөлдөлт	№14	Зуухан цех	2024.10.25
15	Компрессор №1 цахилгаан хөдөлгүүрийн гэмтэл	№15	Нэгдсэн цех	2024.12.02
16	Уутат шүүлтүүрийн орой дээрх салхилуур	№16	Зуухан цех	2024.12.04
17	Зуух №2-ийн удирдлагын модуль	№17	Нэгдсэн цех	2024.12.04
18	Зуух №1-ийн анхдагч агаарын салхилуурын 1-р холхивч	№18	Нэгдсэн цех	2024.12.04

Хүний амь эрсэдсэн, бүлэг болон хүнд осол, аваари гаргасан эсэх

2024 онд ДҮТ ТӨХХК-ийн мэдлийн тоноглолуудад аваари 1 удаа, 2 зэргийн саатал 1 удаа тус тус үүссэн.

Технологийн зөрчил №1: 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 05:24 минутад СУН №1, 2-ын 1600 кВт-ын давтамж хувиргуурын хөргөлтийн сэнс ажиллагаагүй болж сэнсний дохиолол ажилласан байна. Давтамж хувиргуурын 1 ширхэг хөргөлтийн сэнсний хөдөлгүүрийн холхивч нурж гэмтсэн (*Давтамж хувиргуур нь нийт 5 ширхэг хөргөлтийн сэнстэй, бүх сэнсний хөдөлгүүрүүд тэжээлийн 1 автоматтай*). Хөргөлтийн сэнсний хөдөлгүүрийн ороомог шатаж богино залгаа үүсч хөргөлтийн бүх сэнс зогссон. 05:51:32 давтамж хувиргуурын модулийн хэт халалтын хамгаалалт ажиллагаанд байсан СУН №2 давтамж хувиргуурийн халалтын хамгаалалтаар зогссон, 05:51:39 секундэд СУН №3-ын 3, 4-р холхивчны доргио 4.5мм/с-с дээш буюу хамгаалалтын тавилд хүрч 05:51:45 секундэд доргионы хамгаалалт ажиллаж зогсоноор технологийн зөрчил буюу аваари үүссэн.

Технологийн зөрчил №2: 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12:24:36 цагт Компрессор №1 цахилгаан хөдөлгүүрийн А фазад газардлага гарч үндсэн барилга 10 кВ тэжээл А таслуур газардлагын хамгаалалтаар тасарч үндсэн барилга 10 кВ СХТ №2-ын АВР-ын төхөөрөмж SID 40А хэвийн ажилласан. Үндсэн барилга 10 кВ секц №1 секц №2-оос тэжээгдсэнээр компрессор №1 цахилгаан хөдөлгүүрийн А фазын газардлагын нөлөөгөөр СУН № 2 давтамж хувиргуурын хамгаалалт ажиллаж СУН №2 цахилгаан хөдөлгүүр зогсоноор технологийн зөрчил буюу I зэргийн саатал үүссэн.

Зураг № 95

Зураг № 96



Зыпар № 97

Intelligent High-Voltage Variable Frequency Speed Regulation System

Date: 2024-02-29 10:07:13
General: 35353.7 H Thu

Total	1216	S/N	43		
Alarm Name	WARNING FOR FAN FAULT		Time	2024-2-28 5:24:49	
Actual Freq	0	Hz	Target freq	43.48	Hz
Input Power	792	kW	Output Power	792	kW
PFI	0.977		PFO	0.81	
Residual Voltage	5	V			
Input Voltage	AB 9630	BC 10075	CA 9891	Output voltage	AB 8912 BC 8718 CA 8454
Input current	A 45.4	B 47.3	C 50.5	Output current	A 63 B 66.2 C 65.8
Unit Info	A1 0000	B1 0000	C1 0000	DC VOLT	A1 918 B1 933 C1 918
	A2 0000	B2 0000	C2 0000		A2 908 B2 918 C2 908
	A3 0000	B3 0000	C3 0000		A3 938 B3 942 C3 938
	A4 0000	B4 0000	C4 0000		A4 938 B4 933 C4 913

Return
Page Down
Fault Records
Operation Log
Save Record

Зыпар № 98



Зыпар № 99




Зураг № 100



Зураг № 101

Зураг №102



Хүснэгт № 93

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он
1	Төлөвлөгөөт бус зогсолт	Тоо	3
2	Хангагчийн буруутай үйл ажиллагаа	Тоо	0
3	Үүнээс Аварь	Тоо	1
	1-р зэргийн саатал	Тоо	0
	2-р зэргийн саатал	Тоо	1
	Үйлдвэрлэлийн осол	Тоо	0
	Гал	Тоо	0
4	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруугаас	Тоо	0
5	Хэрэглэгчийн буруугаас	Тоо	0
6	Бусад шалтгаанаар	Тоо	1

Шугам хоолойн ханын зузааны хэмжилт

Зуух №3-ын галын хотлын 332 ширхэг хоолойн 3 түвшин, 3 цэгт нийт 2988 удаагийн хэмжилт гүйцэтгэснээр галын хотлын нүүрний экраны 3 ширхэг, зүүн хананы экраны 3 ширхэг, баруун талын экраны 15 ширхэг, нийт 21 ширхэг хоолой 3.5мм-ээс доош буюу 30%-иас дээш элэгдэлтэй гарсан. Урсгал засварын ажлаар зүүн талын 7.5м дээр 98, 99 урд талын 7.5м дээр 1 экран хоолойнууд, зүүн талын 12м дээр 65-р, баруун талын 12м дээр 14,31,33,34,37,67 экран хоолойнууд оруулга оруулж сольж засварласан.

Зураг № 103

Зураг №104




Зураг №105




Зуух №2-ын галын хотлын экран хоолойд хэмжилт хийхэд MNS 6967:2022 стандартын 7.7.11-т Хэт авиа болон бусад хяналтын аргаар бүртгэгдсэн халах гадаргуугийн шулуун хэсгийн ханын нимгэрэлт нэрлэсэн зузааны 30%-иас илүүгүй боловч 1.5мм-ээс

хэтрээгүйг хүлээн зөвшөөрнө гэж заасны дагуу 30%-иас дээш элэгдэлтэй хоолойг тооцож үзвэл зуух №2-т 27 ширхэг хоолой солих шаардлагатай байна. Мөн 20-30% элэгдлийг тооцож үзвэл 123 ширхэг хоолой байна. Хэмжилтээр 3,5-аас доош хэмжилтийн утгатай Зуух №2-т нийт 4 ширхэг солих шаардлагатай экран хоолой байна. Үүнд: Зүүн хананы маталттай хэсгийн 21-р хоолой баруун хананы 6 метрт 12, 16, 66-р хоолойг сольж засварласан.

Зураг №106



Зураг № 107




Зураг № 108




Зуух №1-ийн галын хотлын экран хоолойд хэмжилт хийхэд MNS 6967:2022 стандартын 7.7.11-т Хэт авиа болон бусад хяналтын аргаар бүртгэгдсэн халах гадаргуугийн шулуун хэсгийн ханын нимгэрэлт нэрлэсэн зузааны 30%-иас илүүгүй боловч 1.5мм-ээс хэтрээгүйг хүлээн зөвшөөрнө гэж заасны дагуу 30%-иас дээш элэгдэлтэй хоолойг тооцож үзвэл зуух №1-ийн 6 мерт нүүрний хананы 48-56-р хоолой, арын хананы 41-49-р хоолой нийт 18 ширхэг хоолойг сольж засварласан.


Зураг № 109




Зураг № 110



Зураг № 111



Зураг № 112



Графикт үзлэг

1. Зуухан цех, ТДЦ, Нэгдсэн цехийн техникийн бичиг баримт болох ТАП, хамгаалалт салгах болон шалгах журнал, тоног төхөөрөмжийн үзлэгийн журнал, ашиглалтын заавар, гэмтлийн журналуудад үзлэг хийсэн. Үзлэгээр илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулж ажилласан.

- 2. Станцын үндсэн болон туслах тоноглолуудад үзлэг шалгалтыг батлагдсан графикийн дагуу хийсэн. Үзлгээр илэрсэн зөрчилүүдийг хугацаат шаардлага өгч арилгуулж ажилласан.
- 3. Зуухан цехийн 96, Түлш дамжуулах цехийн 69, Цахилгааны хэсгийн 262 нийт 427 ширхэг техник ашиглалтын паспортнуудад сар бүрийн 2 дох долоо хоногт цаг бүртгэл, үзлэг үйлчилгээ, урсгал болон их засварын хөтлөлтийг шалгаж тухай бүр зөрчил дутагдалыг арилгуулан ажилласан. Мөн ДХХА хэсгийн хэмжүүрт 30 ш ТАП нээлгүүлж ажилласан.

Төлөвлөгөөт ажлууд

- 1. 2024 оны 04-р сарын 04 өдрийн А/65-р тушаалаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдолтой бараа материал болон ажил, үйлчилгээг актаар хүлээн авах комиссын гишүүнээр орж шаардлага хангаагүй бараа, ажил үйлчилгээг зөрчил арилгуулж ажилласан.
- 2. 2024 оны 04 сарын 11-ний өдрийн А/92-р тушаалаар Эрчим хүчний салбарын улсын ахлах байцаагчийн албан шаардлагын дагуу ажлын төлөвлөгөө гарган зөрчлийг арилгуулж ажилласан.
- 3. ХАБЭА-н 3 шатны үзлэгт оролцож илэрсэн зөрчлүүдийг арилгуулан ажилласан.
- 4. 2024-2025 оны өвлийн бэлтгэл ажил хангах үйлдвэрлэлийн их болон урсгал засварын ажлуудад хяналт тавьж ажиллаж байна.
- 5. Нийт ажилтнуудын ээлжит шалгалтаар техник ашиглалтын дүрмээр шалгалтын материал бэлдэж, шалгалтанд хяналт тавьж ажиллав.
- 6. Сар бүр технологийн зөрчлийн мэдээг гаргаж, нэгтгэн ДҮТ-ийн techinfo.energy.mn сайтад оруулж ажиллаж байна.
- 7. Даралтат сав, зуухны техникийн магадлагаа СХБайцаагчаар хийлгэсэн.
- 8. Технологийн хамгаалалтуудад үзлэг хийсэн.
- 9. ААД, ТАД, ГАБ-ын гэнэтийн үзлэг цех хэлтсүүдэд хийгдэж дүнг нэгтгэж байна.
- 10. ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн стандарт нэвтрүүлэх багт ажиллаж амжилттай нэвтрүүлсэн. Мөн дотоод аудиторын сургалтад хамрагдсан.
- 11. Амгалан дулаан станц ТӨХК-ийн нийт 13 цэгт газардуулгын хэмжилт туршилтыг Perfect solution engineering ХХК-иар хийлгэж ажилласан.
- 12. Амгалан дулаан станц ТӨХК-ийн нийт 232 ширхэг анхан шатны хамгаалах хэрэгслийн багаж туршилт хийлгэж ажилласан.

Хэмжилт туршилтын тайлан

Зураг № 113



Хэмжилт туршилтын тайлан


Захиалагч : Амгалан дулааны станц ТӨХК
Гүйцэтгэгч : Перфект солюшн энд инженеринг ХХК
Гэрээний дугаар : Ажил гүйцэтгэх гэрээ №24/80
Байршил : БЗД, 8-р хороо, УС-15-1-1, Амгалан дулааны станц
Огноо : 2024 оны 06 дугаар сарын 06

- Газардуулгын хэмжилт :

Нийт 13 цэгийн газардуулгыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "АЕМС -6471 Ground Tester" багажаар Хэмжилт туршилтын инженер Н Сандагдорж гүйцэтгэв.Хэмжилтээр газардуулгын норм хангасан. /Хэмжилтийн протокол хавсаргав/



Зураг № 114



- Анхан шатны хамгаалах хэрэгслийн багаж туршилт :

№	Хэрэгслийн нэр	Тэнцсэн	Тэнцээгүй	Нийт
1	Хөндийрүүлэх штанг	11	-	11
2	Бахь	9	-	9
3	Резинэн бээлий	13	9	22
4	Резинэн бойтог	24	-	24
5	Хүчдэл заагуур	14	-	14
6	Резинэн дэвсгэр	21	25	26
7	Хөндийрүүлтэй бариултай багаж	126	126	126

Хамгаалах хэрэгслийн үзлэг, туршилтын нормын дагуу туршилтын инженер Э Мөнхзул 110кв хүртлэх хэвийн хүчдэлээр 5 минутын үргэлжлэх хугацаагаар туршив.

Тэнцсэн хамгаалан хэрэгслүүд дээр дардас дарав. Тэнцээгүй хэрэгслийг устгах шаардлагатай.

Тайлан бэлтгэсэн :

Ж.Жавхлан /Ерөнхий менежер/

Галын аюулгүй байдлын дүрэм журмын мөрдөлт

Хяналтын хэлтэс нь галын аюулгүй байдлын дүрэм журмыг мөрдөж галын аюулгүй байдлын зөрчил гаргаагүй ажилласан .

1. Нийт ажлын байр буюу өөрсдийн хариуцсан ажлын байруудын галын хор, галын сараа, галын гидрант, бүрт батлагдсан хуваарийн дагуу үзлэг хийж, хяналтын карт хөтлөлтөнд тогтмол хяналт тавьж ажиллахаас гадна илэрсэн зөрчлүүдийг тухай бүрт үйлдвэрлэлийн шуурхай хуралдаанд танилцуулж, арилгуулах арга хэмжээ авч ажилласан.
2. Засварын ажил хийж гүйцэтгэх үедээ галын хорыг хажуудаа байрлуулах, галын аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг авч галаас урьдчилан сэргийлж ажилласан.
3. Галын аюултай ажил гүйцэтгэх үедээ ажлын байрны нүүрс тоос шатах материал зэргийг сайтар цэвэрлүүлж ажлын байрыг бэлдэж ажилд орох зөвшөөрөл авч ажилласан.

ДОЛОО. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн талаар

Төлөвлөгөөний дагуу 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр зуух №1-ийг зогсоож, 2 зуухны горимд шилжсэн ба Зуух №4-ыг 4 дүгээр сарын 24-ны өдөр зогсоож 1 зуухны горимоор ажиллаж, 05 дугаар сарын 13-ны өдөр бүрэн зогсолт хийж сүлжээнээс таслагдан 0 зогсолт хийсэн.

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр сүлжээнд залгагдан 10 дугаар сарын 2-ны өдрөөс ачаалал нэмэгдэж 2 зуухны горимд, 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 3 зуухны горимд тус тус шилжсэн ажилласан.


2024 онд 1,079,661.9 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 1,041,124.8 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 38,537.1 Гкал дутуу үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 96.4% байна. Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,867.8 Гкал дулааны эрчим хүч илүү үйлдвэрлэсэн байна. Дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийг бүтцээр нь харьцуулбал:

1. Дулааны эрчим хүч түгээлтэнд-98.3%
2. Дотоод хэрэгцээний дулааны эрчим хүчинд-1.7%

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн биелэлтийг сар бүрээр харуулбал

График №40

2024 оны дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн үйлдвэрлэл /Гкал/



2024 оны ДЭХ-ний үйлдвэрлэлийг 2023 оны үйлдвэрлэлийн үр дүнтэй харьцуулбал


Хүснэгт № 94

Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Дулааны эрчим хүчний үйлвэрлэл	мян.Гкал	1,037.2	1,079.6	1,041.1	38.5	3.9

2020-2024 оны ДЭХ-ний үйлдвэрлэлийг харуулбал

График №41

2020-2024 оны дулааны эрчим хүч үйлдвэрлэл /Гкал/



Дулааны эрчим хүч түгээлт

2024 онд 1,064,587.1 Гкал дулааны эрчим хүч түгээхээс 1,025,937.2 Гкал дулааны эрчим хүч түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 38,650 Гкал дутуу түгээж төлөвлөгөөний биелэлт 96.4% байна. Дулаан түгээлийн төлөвлөгөө тасарсан шалтгаан нь 2024 оны 12-р сард сүлжээний усны зарцуулалтыг 4650 тн/цагаар төлөвлөснөөс 4086 тн/цагаар өгсөн. Энэ нь гадна агаарын температур өмнөх жилээс 6-8 С-р дулаахан байсантай шууд хамааралтай. Диспетчерийн графикийн зөрчилгүй, горимд оногдох төлөвлөгөө 100% биелэсэн. Өмнөх оноос дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 3.9 Гкал-аар илүү түгээсэн байна.


Тайлант хугацааны дулааны эрчим хүчний түгээлтийг төлөвлөгөө болон өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан дараах хүснэгт болон графикаар харуулбал

Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
УБДС ТӨХК	мян.Гкал	1,023.23	1,064.58	1,025.93	38.6	2.7
Өөрийн түгээлт	мян.Гкал	1.002	1,055.5	1,035.7	19.8	0.034
Нийт	мян.Гкал	1,024.23	1,065.63	1,026.96	38.6	2.73

Дулааны эрчим хүчний түгээлтийг сүүлийн 5 жилээр графикаар харуулбал

График №42


2020-2024 оны дулааны эрчим хүч түгээлт /Гкал/



Дотоод хэрэгцээнд зарцуулсан дулааны эрчим хүч

График №43

Дотоод хэрэгцээнд зарцуулсан дулааны эрчим хүч /сараар /Гкал/



Дотоод хэрэгцээний дулааны эрчим хүчинд 14,019 Гкал дулааны эрчим хүч зарцуулахаар төлөвлөсөнөөс 14,152 Гкал буюу 132.7 Гкал дулааны эрчим хүчийг илүү зарцуулсан. 2024 оны 4 дүгээр сараас эхлэн 4-р зуух шинээр ашиглалтанд орсонтой холбогдуулан өргөтгөлийн болон шинээр ашиглалтанд орсон барилга байгууламж /Үүнд: үнс хадгалах 7000м³ багтаамжтай 4 силос, үндсэн барилгын 8-р тэмдэгтийн өргөтгөл, вагон гэгсгээгчийн барилга, утаа сорогчийн барилга гэх мэт/ нэмэгдэж дотоод хэрэгцээний дулааны эрчим хүчний зарцуулалт нэмэгдсэн байна. Өргөтгөлийн төслөөр шинээр баригдсан барилга байгууламжийн дулааны нийт ачаалал 2.1 Гкал/цаг байна.

График №44

2020-2024 онуудад дотоод хэрэгцээнд зарцуулсан ДЭХ /Гкал/



2024 оны жишмэл түлшний хувийн зарцуулалт

Хүснэгт № 96

Жишмэл түлшний хувийн зарцуулалт		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жигнээн дундаж
Кг/Гкал	төлөвлөгөө	164.9	175.9	172.1	157.7	161.8	174.0	171.15	170.31	170.03	172.47
	биелэлт	164.9	175.9	172.1	157.7	161.8	163.32	164.21	175.6	181.1	171.3

2020-2024 онуудын жишмэл түлшний хувийн зарцуулалт

Хүснэгт № 97

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Жишмэл түлшний хувийн зарцуулалт төлөвлөгөө /кг/Гкал/	164.2	159.8	161.4	162.9	172.5
Жишмэл түлшний хувийн зарцуулалт биелэлт /кг/Гкал/	158.7	160.7	167.8	164.9	171.3

2023 оны жишмэл түлшний хувийн зарцуулалттай харьцуулсан харьцуулалт


Хүснэгт № 98

Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Кг/Гкал	164.9	172.5	171.3	1.2	6.4

2020-2024 оны жишмэл түлшний хувийн харьцуулалт

График №45


2020-2024 оны жишмэл түлшний хувийн зарцуулалт /кг/Гкал/



2024 оны жишмэл түлшний хувийн харьцуулалт

График №46

2024 оны жишмэл түлшний хувийн зарцуулалт /кг/Гкал/



2024 онд жишмэл түлшний хувийн зарцуулалт 172.5 кг/Гкал-ийн төлөвлөгөөтэй байснаас 171.3 кг/Гкал-ийн гүйцэтгэлтэй байна. Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2024 оны 1, 2, 3, 11, 12 дугаар саруудад 5.6-11.1 кг/Гкал-аар илүү байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. 2024 оны 1 дүгээр сард Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн уурхайн нүүрсний илчлэгийг 3250 Ккал/кг-аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2776 Ккал/кг, нийт илчлэгийн зөрүүнээс 3711 тн нүүрс илүү зарцуулсан. Мөн чийглэг 39,5-42,8% хүртэл өсөж, дунджаар 42,8% ирсэн байна. Жишмэл түлшний хувийн зарцуулалтын төлөвлөгөө 162.5 кг/Гкал-аас гүйцэтгэлээр 164.9 кг/Гкал болж нэмэгдсэн байна.

2. 2024 оны 2 дугаар сард Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн нүүрсний илчлэгийг 3250 Ккал/кг -аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2878 Ккал/кг илчлэгтэй нүүрс ирсэн.

3. Ккал/кг илчлэгтэй нүүрс ирсэн. Мөн чийглэг 40,7-43,7% хүртэл өсөж, дунджаар 42,08% ирсэн байна. Зуухны ашигт үйлийн коэффициентийг төлөвлөсөнөөс 3.7%-иар бууруулснаас шалтгаалж жишмэл түлшний хувийн зарцуулалт нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нийт илчлэгийн зөрүүнээс 2058 тн нүүрс илүү зарцуулсан. Тухайн сард жишмэл түлшний хувийн зарцуулалтын төлөвлөгөө 162.8 кг/Гкал-аас гүйцэтгэлээр 175.9 кг/Гкал-аар нэмэгдсэн байна.

4. 2024 оны 3 дугаар сард Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн нүүрсний илчлэгийг 3250 Ккал/кг -аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2930 Ккал/кг илчлэгтэй нүүрс ирсэн байна. Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний илчлэгийг 3000 Ккал/кг -аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2966.5 Ккал/кг илчлэгтэй нүүрс ирсэн байна. Мөн чийглэг 36,8-43,03% хүртэл өсөж, дунджаар 40,76% ирсэн байна. 03 дугаар сард 118,842.3 Гкал ДЭХ үйлдвэрлэсэн нь 3 дугаар сарын 6-ны өдрийг хүртэл 3 зуухны ашиггүй горимоор ажилласантай холбоотой. Нийт илчлэгийн зөрүүнээс 1731 тн нүүрс илүү зарцуулсан. Жишмэл түлшний хувийн зарцуулалтын төлөвлөгөө 162.6 кг/Гкал-аас гүйцэтгэлээр 172.1 кг/Гкал болж нэмэгдсэн байна.

5. 2024 оны 1-5 дугаар саруудад Цэцэнс Майнинг энд Энержи ХХК-ийн нүүрсний илчлэг төлөвлөгөөнөөс 50-260 Ккал/кг -аар бага ирснээс зуухны буух хоолой бөглөрч зуухны ашигт үйлийн коэффициент буурч жишмэл түлшний хувийн зарцуулалт өмнөх оноос 6.4 кг/Гкал-аар илүү гарсан. 2024 оны 1-3 сард нүүрс худалдах, худалдан авах гэрээнд Цэцэнс уурхайн нүүрсний илчлэгийг 3300 Ккал/кг-аар, чийглэгийг 38%-р тусгасан боловч бодит байдал дээр илчлэг дунджаар 2788-2930 Ккал/кг-аар, чийглэг-40,5-42,4%-тай ирсэн.

6. 2023 оны 11 дүгээр сард Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн уурхайд соляркны хомсдол үүссэний улмаас 10 хоног үйл ажиллагаа нь доголдсон. Үүнээс шалтгаалан 2024 оны 1,2,3 дугаар сард Амгалан Дулааны станцад нийлүүлэх нүүрсийг урьдчилан цагаалга хийх боломжгүй болж чийгтэй нүүрс ачиж явуулах болсноор илчлэг 100-260 кг/ккал-аар бага ирэх болсноор жишмэл түлшний хувийн зарцуулалт нэмэгдсэн. Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн уурхайн нүүрсний илчлэгээс хамаарч 7505 тн нүүрс илүү зарцуулсан.

7. Мөн 2024 оны 8 дугаар сард Шивээ-Овоо ХК-ийн уурхайд үер буусны улмаас уурхай усанд автсан. Үүнээс шалтгаалан 2024 оны 11, 12 дугаар сараас эхлэн Амгалан Дулааны

нийлүүлсэн нүүрсний чийглэг 39,5-43,8%-р ирснээс зууханд дутуу шаталт үүсч зуухны ашигт үйлийн коэффициент буурсан. Шивээ-Овоо ХК-ийн уурхайн нүүрсний чийглэгээс хамаарч 2740 тн нүүрс илүү зарцуулсан

8. 2024 оны 11 дүгээр сард Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний чийглэг 39.1%, илчлэг 2968.5 Ккал/кг-аар ирсэн байна. Мөн 11 дүгээр сарын 3-ны өдрөөс 30-ны өдөр хүртэл 3 зуухны горимоор 71 Гкал/цагийн ачаалалтай ажилласан. Нийт илчлэгийн зөрүүнээс 264 тн нүүрс илүү зарцуулсан. Жишмэл түлшний хувийн зарцуулалтын төлөвлөгөө 170.03 кг/Гкал-аас гүйцэтгэлээр 175.6 кг/Гкал болж нэмэгдсэн байна.

9. 2024 оны 12 дугаар сард Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний чийглэг 42.8%, илчлэг 2894 Ккал/кг-аар ирсэн байна. Нийт чийглэгийн зөрүүнээс 2570 тн нүүрс илүү зарцуулсан. Зууханд чийглэг өндөр нүүрс дутуу шатаж зуухны Q₂-Q₄ хүртэл алдагдлууд нэмэгдэж зуухны ашигт үйлийн коэффициентийг 86% төлөвлөснөөс 82.5% хүрч буурсан байна. Жишмэл түлшний хувийн зарцуулалтын төлөвлөгөө 172.5 кг/Гкал-аас гүйцэтгэлээр 171.3 кг/Гкал болж нэмэгдсэн байна.

Цэцэнс майнинг энд нержи ХХК-ийн нүүрсний чанар, дундаж илчлэг

Хүснэгт № 99

	Дэгдэмхий бодис %	Чийглэг %	Хүхэрлэг %	Үнслэг %	Илчлэг Ккал/кг
2024.01	48.56	41.80	0.99	9.79	2776
2024.02	46.58	42.45	1.00	8.68	2871
2024.03	45.79	40.50	0.98	9.2	2930

Шивээ-Овоо уурхайн нүүрсний чанар, дундаж илчлэг

Хүснэгт № 100


	Дэгдэмхий бодис %	Чийглэг %	Хүхэрлэг %	Үнслэг %	Илчлэг Ккал/кг
2024.01	43.74	41.89	0.99	8.96	2959
2024.02	43	42.29	0.98	9.23	2874
2024.03	45.63	40.74	0.98	9.36	2901
2024.09	42.8	38.63	1.01	11.38	3033
2024.01.10	43.81	40.07	0.95	10.95	2962
2024.01.11	44.68	39.11	0.97	12.72	2902
2024.01.12	43.03	42.83	10.5	10.5	2816

Нүүрсний шинж чанар, хэрэглээг уурхай тус бүрээр харьцуулбал

Шивээ-Овоо уурхайн нүүрсний чийглэг, илчлэг

График №49

Шивээ-Овоо уурхайн нүүрсний чийглэг, илчлэг



Нүүрсний зарцуулалт

2024 онд 423,216.64 тонн нүүрс зарцуулах төлөвлөгөөтэйгөөс 407,250.7 тонн нүүрс зарцуулж 15,965.9 тонн нүүрс бага зарцуулсан буюу 96.2%-ийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 21,153.7 тонн буюу 5.4%-иар нүүрсний зарцуулалт нэмэгдсэн байна

2024 оны нүүрсний зарцуулалт /уурхай бүрээр/

Хүснэгт № 101


Нүүрсний уурхайн нэр	Зарцуулсан хэмжээ /тонн/	Дундаж дулаан гаргах чадвар /ккал/кг/	Нийт нүүрсний злэх хувь /%/
Цэцэнс майнинг энд энерги ХХК	71'924.26	2'909.39	17.6
Багануур ХК	29'328	3'600	7.2
Шивээ-Овоо ХК	289'276.3	2'968.47	71.03
Алагтолгой	16'722.16	3'477.59	4.1
Нийт	407'250.7	3'024.35	100.0

2024 онд Шивээ-Овоо уурхайн нүүрс хамгийн их хэмжээгээр буюу нийт нүүрсний 71.03%-ийг эзэлж байна. Жилийн дундаж дулаан гаргах чадвар 3024.35 ккал/кг байна.

2024 оны нүүрсний бодит зарцуулалт

График №50


Бодит нүүрсний зарцуулалт /тн/



2024-2024 оны нүүрсний зарцуулалт

График №51

2020-2024 оны нүүрсний зарцуулалт /тонн/



Зарцуулсан нүүрс, үнслэгийн хэмжээ

Хүснэгт № 102

Үзүүлэлт	Х/н ж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Дүн
Нүүрсний зарцуулалт	Тн	76500	72500	48000	30500	6000.7	8650	34100	54000	77000	407250.7
Үнсний хэмжээ	Тн	7397	6843	4041	3099.4	531	836	3793	6742	9032	42315
Үнслэгийн хувь	Хувь	9.7	9.4	8.4	10.2	8.8	9.84	10.84	12.58	11.73	10.4

Тайлант онд нийт 407,250.7 тонн нүүрс зарцуулсан. Үнслэгийн хэмжээ 42,315 тонн буюу 10.4% байна.

Нэмэлт усны зарцуулалт


Хүснэгт № 103

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нэмэлт усны Төлөвлөгөө /тн/	252400	252720	274345	225591	315072
Нэмэлт усны Гүйцэтгэл /тн/	118382	122221	135048	177736	208712

2020-2024 оны нэмэлт усны зарцуулалт

График №52

2020-2024 оны нэмэлт усны зарцуулалт /тонн/




Нэмэлт усны зарцуулалт /2023/2024 оны харьцуулалт/

Хүснэгт № 104

Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Нэмэлт усны зарцуулалт	Тонн	177736	315072	208712	106360	30976

2024 оны нэмэлт усыг 2023 онтой харьцуулбал

График №53



2024 оны төлөвлөгөөгөөр 315,072 тонн нэмэлт усыг сүлжээнд нийлүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 208,712 тонн нэмэлт ус зарцуулж 106,360 тонн нэмэлт ус бага зарцуулж ажилласан.

Сүлжээний усны зарцуулалтын гүйцэтгэл, суурилагдсан хүчин чадлын ашиглалт

2020-2024 оны сүлжээний усны зарцуулалт

График №54




2024 онд дунджаар сүлжээний усны зарцуулалтыг 2949 тн/цаг байхаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр сүлжээний усны дундаж зарцуулалтыг 2930 тн/цагаар барьж ажилласан байна.

2024 оны сүлжээний усны дундаж зарцуулалт

График №55

2024 оны сүлжээний усны дундаж зарцуулалт /тонн/ц/



2024 оны 12 дугаар сард сүлжээний усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 12.1%- иар буурсан байна. 2024 оны 12 дугаар сард гадна агаарын температур өмнөх оноос 6-8°C-р дулаан, ОСНААУГ-н 2-р хэлхээний температур 74°C-тэй барьж ажилладаг байсныг 64°C-р барьж ажилласантай холбоотойгоор сүлжээний усны зарцуулалтыг 564 тн/цагаар бага барьж ажилласан байна.

Сүлжээний усны зарцуулалт /2020-2024 он/

Хүснэгт № 105

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Сүлжээний усны зарцуулалтын Төлөвлөгөө /тонн/цаг/	2292	2417	2751	2966	2949
Сүлжээний усны зарцуулалтын Гүйцэтгэл /тонн/цаг/	2360	2302	2552	2881	2930

2024–2025 оны халаалтын улиралд Улаанбаатар хотын оргил ачааллын үеийн нийлбэр сүлжээний усны зарцуулалт 28,357 тонноос Амгалан дулааны станц ТӨХК-ийн сүлжээний усны зарцуулалт 4,348 тонн хүрснээр 15.3%-ыг эзэлж байна.


Сүлжээний усны зарцуулалт /2023/2024 оны харьцуулалт/

Хүснэгт № 106

Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Сүлжээний усны зарцуулалт	тонн/цаг	2882	2949	2930	99.3%	101.6%

2024 оны суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг 2023 онтой харьцуулбал

График №56



2024 онд суурилагдсан хүчин чадлын оргил ачаалал нь 12 дугаар сард 64% хүрсэн бол хамгийн бага ачаалал нь 05 дугаар сард 15.3%-ийн ачаалалаар ажилласан байна. 2023 оны 12 дугаар сард суурилагдсан хүчин чадлын ашиглалт 90% хүрсэн нь тухайн үед 3 зуухны горимоор ажиллаж байсан. 2024 оны 4 дүгээр сараас эхлэн 4-р зуух ашиглалтанд орсноор 4 зуухны горимоор ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан суурилагдсан хүчин чадлын ашиглалт буурсан үзүүлэлттэй байна.

2020 онд суурилагдсан хүчин чадлын ашиглалтын хэмжээ 46.7% байснаас Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээтэй уялдан 2024 онд 51.6% болж нэмэгдсэн байна.

2020-2024 оны суурилагдсан хүчин чадлын ашиглалт





График №57

2024 оны суурилагдсан хүчин чадлын ашиглалт

График №58

2024 оны суурилагдсан хүчин чадлын ашиглалт /%/



ДҮТ ТӨХХК-иас өгсөн горимын биелэлт

Хүснэгт № 107


Үзүүлэлт	Нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жил-ээр
Температурын горим	°C	122/60	119.4/59	104.6/55.2	91.8/50.7	86.9/47.8	85.6/48.2	92.3/50.9	101.4/53.9	115.3/57.9	102.3/51.3
Температурын гүйцэтгэл	°C	122.8/55.9	119.4/54.6	105.7/50.2	92.6/47.01	87.26/47.01	85.68/47.12	92.4/47.7	101.8/50.03	120.0/56.3	105.0/50.1
Даралтын горим төлөвлөгөө	ата	8.5/2.0	8.5/2.0	8.5/2.0	8.3/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.4/2.0	8.0/2.0	7.9/2.0
Даралтын горим гүйцэтгэл	ата	8.5/2.0	8.5/2.0	8.5/2.0	8.3/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.4/2.0	8.0/2.0	7.9/2.0
Сүлжээний усны зарцуулалт төлөвлөгөө	Тонн/цаг	3861	3436	3194	2667	1400	1400	2650	3830	4300	3578
Сүлжээний усны зарцуулалт гүйцэтгэл	Тонн/цаг	3861	3436	3194	2667	1358	1358	2380	3469	4136	2881

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ

2024 онд 37,977.26 МВт цахилгаан эрчим хүч зарцуулах төлөвлөгөөнөөс 35,451.27 МВт цахилгаан эрчим хүч зарцуулсан байна. 2023 онд 37,133.17 МВт цахилгаан эрчим хүч хэрэглэж, өмнөх оноос 1681.9 МВт цахилгаан эрчим хүчийг бага зарцуулж өмнөх оноос цахилгаан эрчим хүчний хэрэглээ 4.5%-иар буурсан байна.

2024 оны цахилгаан эрчим хүчний зарцуулалт

График №59



2020-2024 оны цахилгаан эрчим хүчний зарцуулалт

График №60



Нүүрс татан авалт, нийлүүлэлт

Хүснэгт № 108

№	Компанийн нэр	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь/%%/	Вагоны тоо	Эзлэх хувь /%%/
1	Шивээ-Овоо ХК	313,170.00	291,306.17	93.02	4424	69.83
2	Цэцэнс майнинг энд энерги ХХК	51,500.00	66,757.44	129.63	1027	16.00
3	Бат-Өөдөө ХХК	22,400.00	13,739.66	61.34	211	3.29
4	Багануур ХК	45,000.00	45,347.10	100.77	691	10.87
	Дүн	432,070.00	417,150.37	96.55	6353	100

Нийт нүүрс нийлүүлэлт

График №61



Нийт нүүрсний хэмжээг өмнөх онтой харьцуулахад 2023 онд 399,951.0 тонн, 2024 онд 417,150.0 тонн буюу 17,199.0 тонноор нэмэгдэж 4.3%-аар өссөн татан авалт хийсэн. Шивээ-Овоо ХК, Цэцэнс майнинг энд энерги ХХК, Бат-Өөдөө ХХК, Багануур ХК-тай нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулан төлөвлөж гүйцэтгэлийг сар бүр хуваарийн дагуу жилийн хугацаанд 6,353 вагон буюу 417,150.0 тонн нүүрс татан авч нөөц бүрдүүлэн гүйцэтгэл 96.55%-тай биелэгдсэн. Уурхай тус бүрээр нүүрсний чанарын үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.


Нүүрсний шинж чанар

Хүснэгт № 109

№	Компанийн нэр	Чийглэг W %	Үнслэг А %	Дэгдэмхий V %	Хүхэрлэг S %	Илчлэг Q ккал/кг
1	Шивээ-Овоо ХК	41.44	9.55	43.47	0.98	2998.2
2	Цэцэнс ХХК	39.18	8.99	47.28	0.97	3051.8
3	Бат-Өөдөө ХХК	13.21	33.21	38.24	1.01	3500
4	Багануур ХК	33.43	10.47	43.12	0.76	3587

Уурхай тус бүрийн нүүрсний чанар

Зураг №115



Нүүрс нөөцлөлт


Хүснэгт № 110

Сар	2023 /хоног/	2024 /хоног/	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	9.00	7.00	24,580.29	69,754.03	76,500.00	17,834.32
2	8.00	4.00	17,834.32	64,315.99	72,500.00	9,650.31
3	9.00	7.00	9,650.31	50,420.48	48,000.00	12,070.79
4	11.00	5.00	12,070.79	26,047.93	30,500.00	7,618.72
5	4.00	5.00	7,618.72	1,058.74	6,000.69	2,676.77
9	25.00	31.00	2,676.77	36,945.48	8,650.00	30,972.25
10	19.00	29.00	30,972.25	41,394.79	34,100.00	38,267.04
11	12.00	19.00	38,267.04	60,975.00	54,000.00	45,242.04
12	9.00	16.00	45,242.04	66,237.74	77,000.00	34,479.78
				417,150.18	407,250.69	

2024 онд “Амгалан Дулааны Станц ТӨХК, “Шивээ-Овоо” ХК-ийн хооронд нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан (ШО24-1/08,24/62: ШО24-1/09, 24/63) тоот гэрээний дагуу уурхай нь станцад **313,170.1** тонн нүүрс нийлүүлэхээс **291,306.17** тонн нүүрс нийлүүлж **93.02%**-иар төлөвлөгөөг биелүүлсэн. Гадна агаар дулаан байснаас 12 дугаар сард авах 59,500 тонн нүүрснээс 43,000 тонн нүүрс татан авч 16,500 тонноор бууруулсан. Хоёр компани хоорондоо 8 удаа албан тоотгоор харилцаж хамтран ажилласан. 2024 оны 12 дугаар сард их хэмжээний хөлдүүстэй, чанарын шаардлага хангаагүй нүүрс ирсэнээс вагон хөмрөгч болон бункерт барьцалдаж буухгүй 22 вагон нүүрс буцаасан. ЭХЗХ-оос 2024 оны 9-р сард 592, 12-р сард 695-р тогтоолоор нүүрсний үнэд өөрчлөлт оруулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөн ажилласан.

Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний нийлүүлэлт

График №63



Гэрээний хугацаанд **4,424** вагон нүүрс ачиж нийлүүлсэн. Жилийн хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **41.44%**, үнслэг **9.55**, хүхэрлэг **0.98%**, **дэгдэмхий 43.47** тооцоонд авсан дундаж илчлэг **2,998.0** ккал/кг гарсан нь чийглэг өндөр үзүүлэлттэй байсан ба бусад нь гэрээний болон стандартын шаардлагыг хангаж байна.

Жилийн хугацаанд нэг вагон нүүрсний дундаж жин **65.84** тонноор даацанд хүргэж ачсан байна.

Цэцэнс майнинг энд энерги ХХК:


Хүснэгт №112

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	25,000.00	16,785.50	67.14	259
2	13,000.00	23,619.22	181.69	361
3	2,500.00	15,354.53	614.18	238
4		1,037.92		16
9				
10				
11				
12	11,000.00	9,960.27	90.55	153
Дүн	51,500.00	66,757.44	129.63	1027

2024 онд “Амгалан Дулааны Станц ТӨХК, “Цэцэнс майнинг энд энерги” ХХК-ийн хооронд нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан 24/112, 2023/61 тоот гэрээний дагуу уурхай нь станцад **51,500.0 тонн** нүүрс нийлүүлэхээс **66,757.44 тонн** нүүрс нийлүүлж **129.63%-иар** биелэгдсэн.

Цэцэнс майнинг энд энерги ХХК-ийн нүүрсний нийлүүлэлт

График №64



Уурхай нь станцад гэрээний хугацаанд **1027** вагон нүүрс ачиж нийлүүлсэн.

Гэрээний хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **39.18%**, үнслэг **8.99%**, дэгдэмхий бодис **47.28%**, хүхэрлэг **0.97%**, дундаж илчлэг **3,051.8** ккал/кг гарсан нь илчлэг гэрээний болон стандартын шаардлагыг хангасан байна. Нэг вагон нүүрсний дундаж жин **65.0** тонн гарсан нь даацандаа хүргэж ачсан байна.

Гэрээний хугацаанд нүүрсний нөөц бүрдүүлэлт, вагон хангалт, нүүрсний чанарын асуудлаар 2 удаа И-мейл хаягаар, 2 удаа уурхай явж газар дээр нь очиж үйл ажиллагаатай танилцаж хамтран ажилласан.

Алаг толгойн уурхай / Бат-Өөдөө ХХК/:


Хүснэгт №113

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
1	3,000.00	2,703.85	67.60	42
2	1,300.00	1,444.30	42.48	22
3		2,187.85		34
9	2,000.00	1,914.74	95.74	29
11	5,000.00	4,865.07	97.30	74
12	8,000.00	623.85	7.80	10
Дүн	19,300.00	13,739.66	71.19	211

Алаг толгойн уурхайн нүүрсний нийлүүлэлт

График №65

Алаг толгойн уурхай нүүрс нийлүүлэлт /тн/



Амгалан Дулааны Станц” ТӨХК нь “Бат-Өөдөө” ХХК-тай нүүрс худалдах, худалдан авахаар байгуулсан 24/66 тоот гэрээний дагуу уурхай нь станцад **19,300.0 тонн** нүүрс нийлүүлэхээс **13,740.0 тонн** нүүрс нийлүүлж **71.19%-аар** биелэгдсэн.

Уурхай нь станцад гэрээний хугацаанд **211** вагон нүүрс ачиж нийлүүлсэн.

Гэрээний хугацаанд уурхайгаас нийлүүлсэн нүүрсний дундаж чийглэг **13.21%**, үнслэг **33.21%**, дэгдэмхий бодис **38.24%**, хүхэрлэг **1.01%**, дундаж илчлэг **3,500.0** ккал/кг гарсан нь гэрээний болон стандартын шаардлагыг хангаж байна.

Багануур ХК:

Хүснэгт №114

Сар	Төлөвлөгөө /тн/	Гүйцэтгэл /тн/	Хувь	Вагоны тоо
9	10,000.00	11,110.50	111.11	167
10	10,000.00	11,350.40	113.50	172
11	10,000.00	10,343.40	103.43	160
12	15,000.00	12,542.80	83.62	192
Дүн	45,000.00	45,347.10	100.77	691

